

СҮХБААТАР ДҮҮРГИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ АЛБАНЫ 2017 ОНЫ ЭХНИЙ
ХАГАС ЖИЛИЙН БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАЛТЫН ТУХАЙ ТАЙЛАН

2017.08.30

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Сүхбаатар дүүргийн Засаг даргын дэргэдэх Худалдан авах ажиллагааны алба нь дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлагдсан төсвийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулан батлуулж, худалдан авах ажиллагааг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, холбогдох тогтоол, журам, зааварт нийцүүлэн зохион байгуулан ажиллаж байна.

1.1. 2017 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлт

а. Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих бараа, ажил, үйлчилгээ худалдан авалт:

Оны эхэнд дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ батлагдаагүй бөгөөд 06 дугаар сарын 19-ний өдрийн ИТХ-аар дүүргийн 2017 оны төсөвт тодотгол хийгдэж, **4072.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 83 төсөл арга хэмжээг** тодотгон баталсан байна. Үүнд:

Дд	Худалдан авах ажиллагааны зохион байгуулалт	Төсөвт өртөг (сая. төг)	Төсөл арга хэмжээний тоо
1	Худалдан авах ажиллагааг бүрэн зохион байгуулсан	1528,7	44
2	Тендер зарлагдсан шатанд	38,2	2
3	Тендер үнэлгээний шатанд	329,0	7
4	Тендер зарлах бэлтгэл ажиллагааг хангаж буй	291,4	8
5	Үнэлгээний хороо байгуулагдсан ч зураггүй ажил	1247,9	20
6	Үнэлгээний хороо байгуулагдаагүй	230,0	1
7	Зураг төсөв	407,6	1
ДҮН		4072,9	83

б. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих бараа, ажил, үйлчилгээ худалдан авалт:

Мөн төсвийн тодотголоор дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2017 онд хэрэгжих 896,5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 36 төсөл арга хэмжээ батлагдсан байна.

Үүнд:

Дд	Худалдан авах ажиллагааны зохион байгуулалт	Төсөвт өртөг (сая. төг)	Төсөл арга хэмжээний тоо
1	Худалдан авах ажиллагааг бүрэн зохион байгуулсан	621,8	30
2	Тендер үнэлгээний шатанд	50,9	1
3	Үнэлгээний хороо байгуулагдсан ч зарлагдаагүй	223,7	5
ДҮН		896,4	36

в. Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих /худалдан авах ажиллагааны эрх шилжин ирсэн/ бараа, ажил, үйлчилгээ худалдан авалт:

Нийслэлийн Засаг даргын 2017 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн А/340 тоот захирамжаар нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2017 онд хэрэгжих 100,0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий тохижилтын ажил хийх 3 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрх шилжин ирсэн. Үүнд:

Дд	Худалдан авах ажиллагааны зохион байгуулалт	Төсөвт өртөг (сая. төг)	Төсөл арга хэмжээний тоо
1	Худалдан авах ажиллагааг бүрэн зохион байгуулсан	100,0	3
ДҮН		100,0	3

1.2. Төлөвлөгөөнд тусгагдаагүй худалдан авах ажиллагааны талаархи тайлбар, үндэслэл болон хэрэгжилтийн талаархи мэдээлэл

г. Дүүргийн төсвийн бусад эх үүсвэрээр хэрэгжих бараа, ажил, үйлчилгээ худалдан авалт.

Дүүргийн Засаг даргын захирамжаар дүүргийн төсвийн нөөц хөрөнгө болон хот тохижуулах зардлаас санхүүжих 18 төсөл арга хэмжээний сонгон шалгаруулалтыг зохион байгууллаа. Эдгээр нь тухайн цаг үеийн шинж чанартай худалдан авалт бөгөөд төлөвлөлтөнд тусгагдаагүй байсан болно.

Тус худалдан авалтын хүрээнд 8 үнэлгээний хороо байгуулагдан нийт 2765,4 сая төгрөгийн өртөг бүхий бараа, ажил, үйлчилгээний сонгон шалгаруулалтыг хэрэгжүүлж байна. Үүнд:

Дд	Худалдан авах ажиллагааны зохион байгуулалт	Төсөвт өртөг (сая. төг)	Төсөл арга хэмжээний тоо
1	Худалдан авах ажиллагааг бүрэн зохион байгуулсан	1954,9	16

2	Тендер зарлагдсан шатанд	295,0	3
3	ҮХ байгуулагдсан бэлтгэл ажиллагааг хангаж буй	515,5	1
ДҮН		2765,4	20

*Төлөвлөгдсөн худалдан авах ажиллагааны хэрэгжилт
(2017 оны 8 дугаар сарын 30-ны байдлаар)*

Дд	Худалдан авах ажиллагааны зохион байгуулалт	Төсөвт өртөг (сая. төг)		Төсөл арга хэмжээний тоо	
		Хэрэг-жүүлбэл зохих	Бүрэн хэрэгжсэн	Хэрэг-жүүлбэл зохих	Бүрэн хэрэгжсэн
1	Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалт	4072,9	1528,7	83	44
2	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт	896,4	621,8	36	30
3	Нийслэлийн Засаг даргаас худалдан авах ажиллагааны эрх шилжин ирсэн хөрөнгө оруулалт /НТХО/	100,0	100,0	3	3
4	Бусад эх үүсвэрээс хэрэгжсэн хөрөнгө оруулалт	2765,4	1954,9	20	16
НИЙТ ДҮН		7834.7	4205.4	142	93
Төлөвлөгөөний биелэлт /хувиар/				65.49%	

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ АЛБА